



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 13 өдөр

Дугаар А/288

Сүхбаатар сум

Ургацын штаб байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "б", 29.1.6 "б", 29.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ургац хураалтын ажлыг технологит хугацаанд нь явуулах, сумдын ургацын штаб, аж ахуй нэгж, иргэдээс ирүүлсэн санал, хүсэлтийг шуурхай шийдвэрлэх зорилго бүхий аймгийн ургацын штабын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ургацын штабын гишүүдийн хариуцсан сум, ажил үүргийн хуваарийг хоёрдугаар, жижүүрийн хуваарийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аймгийн ургацын штабын даргад даалгах нь:

2.1. 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн ургац хураалт дуусах хүртэлх хугацаанд ургацын штабыг Хүнс, хөдөө аж ахуйн газарт байрлуулж, шаардлагатай үед уртасгасан цагаар ажиллуулах;

2.2. Ургацын штабын жижүүрүүд хуваарийн дагуу ажиллаж байгаа эсэх, сумдаас ирүүлсэн явцын мэдээний бодит байдалд хяналт тавьж, дүгнэлт хийж холбогдох арга хэмжээг авч ажиллах;

3. Аймгийн ургацын штабын гишүүдэд даалгах нь:

3.1. Хариуцсан сумын ургацын штабыг удирдлага зохион байгуулалтаар хангаж, ургац хураалтын бэлтгэл ажлыг бүрэн хангуулж, байнгын ажиллагаатай эсэхэд нь хяналт тавих, балансаар тогтоогдсон ургацыг бүрэн хураалгах зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах;

4. Сумдын Засаг дарга нарт даалгах нь:

4.1. Ургац хураалтад шаардлагатай ажиллах хүн хүч, техник, шатахуун, тээвэр, үтрэм, агуулах, зоорины бэлэн байдлыг хангуулах, хүсэлт гаргасан иргэн, аж ахуй нэгжүүдэд техникээр үйлчлэх ажлыг сум дотор нь зохион байгуулах;

4.2. Сумын ургацын штабыг байгуулж, штабын гишүүдийн ажил үүргийн хуваарийг баталж, ургац хураалтын ажлыг шуурхай зохион байгуулж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллах;

4.3. Ургац хураалтад ажиллах техникийн засвар үйлчилгээг чанартай хийлгэж, уртасгасан цагаар ажиллах нөхцөл бололцоогоор хангаж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааврыг танилцуулан мөрдүүлж ажиллах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

4.4. Техникгүй иргэн, аж ахуйн нэгжид үйлчилгээ үзүүлэхдээ тухайн орон нутгийн баталсан жишиг үнэлгээг мөрдөж ажиллах;

430810571

4.5. Ургац хураалтын явцын мэдээг долоо хоног бүрийн Даваа, Пүрэв гаригийн 12:00 цагаас өмнө аймгийн ургацын штабт /утас-70363500/ тогтмол илтгэх, мэдээний бодит байдалд хяналт тавьж, цаг агаарын мэдээг аж ахуй нэгж, иргэдэд шуурхай хүргэх ажлыг зохион байгуулах;

4.6. Сумдын Газар тариалан хариуцсан мэргэжилтнүүдийн үүрэг хариуцлагыг өндөржүүлж удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах;

4.7. 2021 оны оны ургац хураалтаас, 2022 оны хаврын тариалалтад шаардагдах улаан буудайн үрийг 100 хувь нөөцлүүлэх арга хэмжээг авч, дүн мэдээг хугацаа хоцроохгүй мэдээлэх;

4.8. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Хууль зүй дотоод хэргийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны А-136/ а-158/210 дугаар тушаалаар батлагдсан "Тариалангийн талбайд мал, тэжээвэр амьтан орсны улмаас тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчид учруулсан хохирлыг тооцох аргачлал"-ын 3.1-д заасны дагуу ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилон, ургацын балансаар тогтоогдсон ургацыг мал, амьтдаас хамгаалж тариалангийн талбайд мал оруулахгүй байх арга хэмжээг тариаланч, малчидтай хамтран зохион байгуулах;

5. Ургацын штабын жижүүрт даалгах нь:


5.1. Штабын жижүүр батлагдсан хуваарийн дагуу ажлын цагаар жижүүрийн үүрэгт ажлыг гүйцэтгэх/ шаардлагатай үед уртасгасан цагаар ажиллах/;

5.2. Ургац хураалтын явцын мэдээг жижүүрийн дэвтэрт тодорхой тэмдэглэж, ирүүлсэн мэдээний бодит байдалд хяналт тавих, мэдээ ирүүлээгүй сумдын холбогдох албан тушаалтнуудтай холбогдон мэдээг заавал авах;


5.3. Сумдаас ирүүлсэн явцын мэдээг хянан нэгтгэж, улсын болон аймгийн ургацын штаб, холбогдох хэлтэс, агентлагийн удирдлагуудыг мэдээ, мэдээллээр хангах, ирүүлсэн санал хүсэлтийг шуурхай шийдвэрлүүлэх;

6. Аймаг, сумын ургацын штабыг цаг уурын урьдчилсан мэдээ, мэдээллээр тасралтгүй хангаж ажиллахыг Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /З.Энхсэлэнгэ/-д даалгасугай.

7. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ургацын штабын дарга аймгийн Засаг даргын орлогч /Ж.Сайнцог/-д даалгасугай.



Аймгийн Засаг даргын 2021 оны 01 дугаар сарын 13-ны өдрийн 13 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



АЙМГИЙН УРГАЦЫН ШТАБЫН БҮРЭЛДЭХҮҮН


Ургацын штабын дарга: Аймгийн Засаг даргын Хөгжлийн бодлогын асуудал хариуцсан орлогч

Нарийн бичгийн дарга: Хүнс хөдөө аж ахуйн газрын Газар тариалангийн албаны дарга

○ Гишүүд:

- Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
- Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
- Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
- Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
- Мэргэжлийн хяналтын газрын дарга
- Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга
- Онцгой байдлын газрын дарга
- Цагдаагийн газрын дарга
- -Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга
- Цэргийн штабын дарга
- Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга
- Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
- Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн хэвлэл мэдээллийн мэргэжилтэн.

Аймгийн Засаг даргын 2021 оны 28 дугаар
сарын 28 ны өдрийн 1122 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт



**АЙМГИЙН УРГАЦЫН ШТАБЫН ГИШҮҮДИЙН АЖИЛ ҮҮРГИЙН
ХУВААРЬ, ХАРИУЦСАН СУМ**

| № | Штабын гишүүдийн албан тушаал | Хариуцах сум | Ажил үүргийн хуваарь |
|----|---|--|--|
| 1 | Засаг даргын орлогч | Алтанбулаг | Штабын гишүүдийг удирдлагаар хангах, штабын гишүүдийн хариуцсан ажилд хяналт тавих. |
| 2 | Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга | Баруунбүрэн | Эрчим хүчээр тасралтгүй хангах, ИТХ-ын 2013 оны 25 дугаар тогтоол болон Засаг даргын захирамжийн хэрэгжилтэд хяналт тавих. |
| 3 | Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга | Баянгол | Шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх. |
| 4 | Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга | Ерөө | Сум орон нутгийг нэгдсэн удирдлагаар хангах, уялдуулан зохицуулах. |
| 5 | Нийгмийн бодлогын хэлтсийн дарга | Жавхлант | Салбар дундын зохицуулалт хийх хүн хүчний нөөц бүрдүүлэх. |
| 6 | Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга | Зүүнбүрэн | Ургац хураалтанд ажиллах техник, хүн хүч, шатахууны асуудал. |
| 7 | Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга | Мандал | Газрын эзэмшилт, ашиглалт зориулалтын бус ашигласн тариалангийн талбайн асуудал. |
| 8 | Мэргэжлийн хяналтын газрын дарга | Орхон | Үр болон таваарын улаан буудай, төмс, хүнсний ногооны стандарт хангуулах, шинжилгээнд хамруулах, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа. |
| 9 | Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга | Орхонтуул | Ургац хураалтын үед ашиглах жин хэмжүүрийг баталгаажуулах, хяналт тавих. |
| 10 | Онцгой байдлын газрын дарга | Сайхан | Шаардлагатай үед нэмэлт хүн хүчний асуудлыг шийдвэрлэх, гал түймрээс урьдчилан сэргийлэх. |
| 11 | Цагдаагийн газрын дарга | Сант | Ургац хураалтын үеийн хэв журмыг сахиулах, тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг хангуулах |
| 12 | Цэргийн штабын дарга | Түшиг | Ажиллах хүн хүчний нөөц бүрдүүлэх. |
| 13 | Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга | Хүдэр | Цаг уурын мэдээг тухай бүр шуурхай хүргэх. |
| 14 | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга | Цагааннуур | Салбар дундын зохицуулалт хийх хүн хүчний нөөц бүрдүүлэх |
| 15 | Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга | Шаамар | Ургац хураалтын зам, гүүрийн засвар үйлчилгээг хангах. |
| 16 | Хүнс, хөдөө аж ахуйн газрын Газар тариалангийн албаны дарга | Хушаат | Ургац хураалтын технологи боловсруулах мэргэжлийн удирдлагаар хангах. |
| 17 | Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжилтэн | Цаг үеийн ажлын явцыг олон нийтэд хүргэж сурталчлах. | |

